


БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Нарантуяа* Б.НАРАНТУЯА



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2017 оны 12-р дугаар сарын 11-ний өдөр

№

2017 12 04 162

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид “Захиалагч” гэх/ түүнийг төлөөлж Статистик, мэдээллийн технологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цэнгүүн, нөгөө талаас 5720095 регистрийн дугаартай Эбо Групп ХХК /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж Ерөнхий захирал Д.Отгонбаатар бид харилцан тохиролцож дараах нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиалгаар “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, хууль, эрх зүйн орчны мэдлэгийг дээшлүүлэх нь” сэдэвт цуврал сургалтыг зохион байгуулахтай холбогдсон талуудын хүлээх эрх, үүрэг хариуцлагыг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Энэхүү гэрээнд Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээнд гарын үсэг зурсан талыг тухайн талаа төлөөлөх бүрэн эрхтэй хэмээн үзэх бөгөөд төлөөлөх эрхгүй этгээдээр гарын үсэг зуруулснаас үүдэн гарах гэрээний хариуцлага, аливаа эрсдэлийг тухайн төлөөлүүлсэн тал бүрэн хариуцна.

1.3 Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн энэхүү Гэрээний 2.1-д заасан гэрээний зүйлийг харилцан бүрэн барагдуулах хүртэлх хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Гэрээний зүйл

2.1 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиалгаар “Хууль, эрх зүйн орчны мэдлэгийг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулах.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

3.1 Захиалагч нь сургалтын явцтай танилцах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, сургалтын чанар, зохион байгуулалтад хяналт тавих.

3.2 Батлагдсан төсвийн дагуу сургалтын зардлыг Гүйцэтгэгч талын нэхэмжлэхийг үндэслэн цаг хугацаанд нь шийдвэрлэж тасралтгүй байдлыг хангах, зарцуулалтад хяналт тавих.

3.3 Сургалтад хэрэглэгдэх хэвлэмэл материалыг цаг тухайд нь хэвлэн нийлүүлэх.

3.4 Захиалагч нь ажлын захиалга өөрчлөх, хугацаа сунгах зэрэг тохиолдолд гэрээний нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж баталгаажуулна.

3.5 Сургалтын зохион байгуулалттай холбоотой доголдолтой зүйл гарвал /хоол хүнс чанарын шаардлага хангаагүй, гүйцэтгэгч талаас харилцааны зүй бус үйлдэл гарах/ Захиалагч доголдлыг арилгуулах, санал гомдлыг шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд зардлыг нөхөн төлүүлнэ.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1 Гүйцэтгэгч нь Захиалагчийн удирдамжийн дагуу сургалтын хөтөлбөр, сургалтын материал боловсруулах.

4.2 Сургалтыг онол, практик хослуулсан байдлаар батлагдсан төсөвт багтаан сургалтын үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд, алдаа дутагдал гаргалгүй зохион байгуулна.

4.3 Суралцагчдын мэдлэг чадвар түвшинг дээшлүүлэхээр шинэ мэдээ мэдээллээр хангах, сургалтын үр дүн гаргах.

4.4 Сургалтын агууламж, хэрэгцээнд тохируулан хэвлэмэл материалын эхийг бэлтгэж, сургалт эхлэхээс 7 хоногийн өмнө Захиалагчид хүлээлгэн өгсөн байна.

4.5 Захиалагчийн өгсөн сургалтын мэдээ, мэдээлэл, тоо баримтын нууцыг хадгалах өөр зориулалтаар ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно.

4.6 Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, стандартыг баримталж, сургалтад хамрагдаж байгаа мэдээллийн технологийн ажилтнуудтай зөв боловсон харьцах.

4.7 Гэрээнд заасан хугацаанд сургалт зохион байгуулагдаагүй эсвэл алдаа дутагдал гарсан тохиолдолд хугацаа хоцорсон хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги хүлээнэ.

4.8 Батлагдсан төсвийн дагуу сургалтын хэрэглэгдэхүүн, амт чанартай хоол хүнсээр хангах.

4.9 Сургалт зохион байгуулсан тайланг Захиалагчид гэрээний үүрэг дууссанаас хойш 7 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

Тав. Гэрээний үнэ, төлбөр төлөх аргачлал

5.1 "Хууль, эрх зүйн орчны мэдлэгийг дээшлүүлэх нь" сэдэвт сургалтын зардал нь 27 420 000 /хорин долоон сая дөрвөн зуун хорин мянга/-н төгрөг байна.

5.2 Талууд гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдөр энэхүү гэрээний 5.1 дэх хэсэгт заасан гэрээний төлбөрийн 50 хувь буюу 13 710 000 /арван гурван сая долоон зуун арван мянга/-н төгрөгийг Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.

5.3 Үлдэгдэл 50 хувийн төлбөрийг сургалт зохион байгуулагдаж дууссаны дараа Гүйцэтгэгчийн гаргасан нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ.

Зургаа. Бусад


6.1 Энэхүү гэрээнд Талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба бичгээр үйлдэнэ.

6.3 Гэрээний явцад үүсэх аливаа маргаантай асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба харилцан тохиролцох боломжгүй бол хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


М.ЦЭНГҮҮН

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

